



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 617

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа хамгаалалтын захиргаадын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 5 нэрийн, нийт 46,700,000.00 (дөчин зургаан сая долоон зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 5 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, яамны харьяа хамгаалалтын захиргааны дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
132006993

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
... дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ХАРЬАА ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААДЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа					
1	УАЗ-220692-033 пургон маркийн, суудлын зориулалттай, 27-71 ХОУ улсын дугаартай, хөдөлгүүрийн багтаамж 2890, арлын дугаар 374100C0483332	2012	343,719	1,500,000.00	2,000,000.00
Говийн Их дархан цаазат газрын А хэсгийн хамгаалалтын захиргаа					
2	УАЗ-315122 суудлын автомашин, 70-31 ГАА улсын дугаартай, хөдөлгүүрийн дугаар 80001660, арлын дугаар 80505638	2008	16,895	14,000,000.00	1,500,000.00
3	Тоёота Ланд круйзер прадо-70, 92-96 ГАА улсын дугаартай, ачааны зориулалттай, хөдөлгүүрийн дугаар 1FJ, арлын дугаар JTFLJ73J216004953	2000		11,200,000.00	5,000,000.00
Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа					
4	УАЗ 315142-012 469 маркийн суудлын автомашин, 50-79 БНА улсын дугаартай, хөдөлгүүрийн дугаар А0002674, арлын дугаар А0563454	2010	3,219	18,000,000.00	2,000,000.00
Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалтын захиргаа					
5	УАЗ 220695-353 пургон маркийн суудлын автомашин, 37-75 ЗАН улсын дугаартай, хөдөлгүүрийн дугаар 410400Б005572, арлын дугаар 374100D0422317	2013	98,943	2,000,000.00	2,000,000.00
НИЙТ ДҮН				46,700,000.00	12,500,000.00
				(дөчин зургаан сая долоон зуун мянган төгрөг)	(арван хоёр сая таван зуун мянган төгрөг)